

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан "Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ний "Дарга: - Монгол Улсын Ерөнхий сайд" гэсний дараа "Орлогч дарга: -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд" гэж, "Гишүүд" хэсгийн "- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга" гэсний дараа "-Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга" гэж тус тус нэмж, мөн хэсгийн "-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны..." гэснийг "-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны...", "-Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Хяналтын зөвлөлийн дарга" гэснийг "-Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал" гэж тус тус өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ